

МБСХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ҮҮРЭГ (Тэмцээн явуулах захиалгын хуудсын хамт хүчин төгөлдөр болно)

Монголын Бүжгийн спортын тэмцээнүүдийн анхны үүсгэн байгуулагч/ хууль ёсны эзэмшигч нь Монголын Бүжгийн Спортын Холбоо болохыг үндэслэн

_____ миний бие

(зохион байгуулагч: овог нэр, телефон, e-mail)

_____ тэмцээнийг

(спортын арга хэмжээний нэр, явагдах огноо, газар)

зохион байгуулах эрхээ авсан тохиолдолд дараах ҮҮРЭГ хүлээж байна:

Тэмцээнд бэлтгэх явцад:

1. Явуулахаас татгалзах

Арга хэмжээг явуулахаар тогтсон хугацаа хүртэл 60 хоногийн дотор тухайн арга хэмжээг явуулахаас татгалзахгүй. Хэрэв арга хэмжээг явуулахаар тогтсон хугацаа хүртэл 60 хоногийн дотор тухайн арга хэмжээг явуулахаас татгалзсан тохиолдолд МБСХ-нд Тэргүүлэгчдийн тогтоосон хэмжээний **торгууль** төлнө.

2. Тэмцээний сурталчилгаа

МБСХ-ны Тэргүүлэгчдийн зөвшөөрсөн тэмцээний анонстой мэдээллийг МБСХ-ны www.mdsf.mn интернэт сайтад МБСХ-ны тогтоосон загвараар байрлуулна.

3. Хэвлэлийн материал

Монголын тэмцээний үүсгэн байгуулагчийн хувьд Монголын Бүжгийн Спортын Холбооны нэр, логог байршуулна

4. Урьдчилсан бүртгэл

Тэмцээн эхлэхээс 30 хоногоос оройтуулалгүй хосуудын урьдчилсан бүртгэлийг зохион байгуулна.

Бүртгэл тооллогын комисстой хамтарч нэг клубээс оролцож байгаа хосуудыг нэг бүлэг болгон бүртгэхгүй өөр өөр клубуудын хосуудтай холих нөхцлийг хангана. Үүнд компьютерийн тохиолдлын тооны программыг ашиглаж болно.

5. Бүртгэл-тооллогын комисс ба программ

Зөвхөн МБСХ-гоор аттестатчилагдсан өгөгдөл боловсруулах программ ашигласан аттестатчилагдсан бүртгэл-тооллогын комисс байна.

6. Шүүгчдийн баг ба тэднийг бүрдүүлэх зарчмыг зөвшилцөх

Шүүгчдийн нэрсийг МБСХ-той тохиролцоно. Шүүгч бүрд урилгыг МБСХ-ны зөвшөөрсөн хуудсаар бичгээр урьдчилан хүргүүлнэ.

7. Бэлтгэл ба зохион байгуулахад гадаадын иргэн ба гадаадын программ оролцуулах

Монголын тэмцээнийг зохион байгуулах, бэлтгэхэд гадаадын иргэнийг оролцуулахгүй. Тухайлбал тэднийг эдгээр тэмцээнийг зохион байгуулах, бэлтгэх ажлын бүрэлдэхүүнд оруулахгүй.

8. Заал ба талбайг чимэглэх

Монголын тэмцээнийг явуулах үед МБСХ-ны лого бүхий хайлт самбарыг бэлтгэнэ.

9. Нээлтийн ёслолын үйл ажиллагаанд бэлтгэх

Монголын болон Олон улсын тэмцээнд МБСХ-ны Ерөнхийлөгч/ Дэд ерөнхийлөгч/ Тэргүүлэгч гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд тэднийг нээлтийн ёслолд албаны хүний хувиар оролцуулна.

10. Шагналын ёслолын үйл ажиллагаанд бэлтгэх

Монголын болон Олон улсын тэмцээнд МБСХ-ны Ерөнхийлөгч/ Дэд ерөнхийлөгч/ Тэргүүлэгч гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд тэднийг шагналын ёслолд албаны хүний хувиар оролцуулна.

Шагналд гурван хос медаль, финалистуудад диплом (диплом болон медаль дээрх текстийг МБСХ-ны Тэргүүлэгчидтэй тохиролцоно), дурсгалын бэлэг болон цэцгийн баглаа бэлтгэнэ.

11. Мөнгөн шагнал

Мөнгөн шагнал гардуулах бол МБСХ-ноос бичгээр зөвшөөрөл авна. Энэ тохиолдолд Монгол улсын нутаг дэвсгэр дээр бэлэн мөнгөний бүх тооцоог төгрөгөөр хийнэ.

Тэмцээний явцад:

1. Оролцох эрхийн хураамж

Төрөл бүрийн насны ангилалын тамирчдын оролцох эрхийн хураамж, үзэгчдийн тасалбарын үнэ нь МБСХ-ны тогтоосон хэмжээнээс ихгүй байна.

2. Бүртгэл-тооллогын комисс

Шүүгчдийн өгөгдлийг зөвхөн автоматаар боловсруулах ба үүнд компьютер, МБСХ-ны тогтоосон программ хангамжийг ашиглана. Хосуудыг бүртгэх үед зэрэглэлийн дэвтэр, эмнэлгийн магадлагаа, золгүй тохиолдлын даатгалын гэрээг шалгана.

Бүх баримт бичгийг ерөнхий шүүгчид тэмцээн явагдаж буй заалаас гарахаас нь өмнө өгнө.

3. Бүртгэл-тооллогын комиссын ажлын байр

Бүртгэл-тооллогын комиссыг орчноос найдвартай тусгаарлаж, бусад хүмүүс энэ комиссын ажилд саад болохгүй байх нөхцлөөр хангана.

4. Шүүгчдийн амрах байр

Тэмцээнд үйлчлэх шүүгчдийн багд зориулж Иметь изолированные комнаты для бригады судей, обслуживающих соревнования.

5. Шүүгчдийн багийн бүрэлдэхүүнийг зарлах

Шүүгчдийг амаар зарлахдаа түүний овог нэрийн өмнө “ноён/хадагтай” гэсэн үгнүүдийг оруулна.

6. Телевизийн нэвтрүүлэг хийх

Арга хэмжээний талаар мэдээ сурвалжлага/ кино зураг авах (аль боломжтойг доогуур нь зур) нөхцлийг хангах ба материалыг эфирээр үзүүлнэ.

7. Эмнэлгийн тусламж

Зааланд тамирчид, үзэгчдэд эмнэлгийн тусламж үзүүлэх эмч нарыг байрлуулна.

8. Хамгаалалт

Зааланд нийтийн эмх цэгцийг хангах, талбайн ойролцоо бүжигчид, үзэгчид овоорох, бөөгнөрөх байдлыг арилгах зорилгоор шаардлагатай тооны тусгай ажиллагсдыг байлгана.

9. МБСХ-ны Тэргүүлэгч гишүүн байлцах

МБСХ-ны Тэргүүлэгчдийн шийдвэрээр тухайн арга хэмжээнд тусгай даалгавраар оролцох МБСХ-ны албаны хүмүүсийн зочид буудал, хоол, унааны хоёр талын зардлыг даана.

10. Тэмцээний төгсгөл

Тэмцээн дууссанаас долоо хоногийн дотор тэмцээний дүнг МБСХ-ны тогтоосон форматаар МБСХ-ны Гүйцэтгэх зөвлөлд илгээнэ. МБСХ-ны www.mdsf.mn вэб сайтаар сурталчилна.

Төгсгөлийн журам

Бид энэхүү мэдэгдэл бүрэн төгс биш болохыг мэдэгдэж, санал нийлж байна. Арга хэмжээ эхлэхээс 60 хоногоос багагүй хугацааны өмнө Тэргүүлэгчдээс мэдүүлж болох нэмэлт үүрэгтэй бид санал эс нийлбэл Тэргүүлэгчид бидний энэхүү арга хэмжээг явуулах эрхийг хасч болно.

Хэрвээ бид дээр дурьдсан үүргээс нэг эсвэл хэдийг зөрчвөл МБСХ-ны Тэргүүлэгчид биднийг цаашид Монголын тэмцээн зохион байгуулах эрхийг хасахыг зөвшөөрч байгаагаа мэдэгдэж байна.